

**МОНГОЛ УЛСАД ХОХИРОГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛД
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ****LEGAL STATUS OF THE VICTIM IN MONGOLIA
SOME ISSUES TO CONSIDER****Б.Наргулан**

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн
сургуулийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа*

Түлхүүр үг: Хохирогч, хохирогчийн эрх зүйн байдал, Шударгаар хандуулах эрх, бодит хохирогч, нуугдмал хохирогч, мэдэх эрх, аюулгүй байх эрх, нотлох эрх, хөндөгдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх;

Key word: The right to fair payment, victim, legal status of the victim, actual victims, latent victims, right to know, the right to be safe, right of proof, the right to redress the rights that have been violated.

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-д хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”. 16-р дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй” 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” Хэмээн эрх зүйт

төрийн үзэл баримтлалын үндсэн дээр иргэний эрхийг тунхаглаж, түүний баталгааг төр хангах үүргийг тусгасан.¹

Төр иргэн хоёр харилцан үүрэг хүлээх шаардлага зүй ёсоор тавигдсан өнөө үед төрөөс иргэдийн өмнө хүлээх хариуцлага улам өндөрсөж, төрийн зүгээс иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг шийдвэрлэх, нөхөн төлүүлэх асуудал хууль зүйн болоод нийгмийн тулгамдсан асуудал болсон байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, аюулгүй байдлыг хангахаас гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийг нотлох ажиллагааны үр дүн шууд хамаарах болж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1985 онд “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал” (Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) баталж, түүний үзэл санааг хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон.

Тунхаглалд зааснаар, хохирогч гэсэн ойлголтод:”...гишүүн улсуудын дагаж мөрдөж байгаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглахыг хориглосон хуулиудыг оролцуулаад, Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие мах бодийн болон оюун санааны хохирол учирсан, сэтгэл санааны дарамтад орсон, эд хөрөнгийн хохирол учирсан, эсвэл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн бие хүн болон хамт олныг ойлгоно²” гэж тодорхойлжээ.

Мөн “хохирогч гэдэг ойлголтод зарим тохиолдолд хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээлгэн тэтгүүлэгчдээс гадна тэжээн тэтгэгч, түүнчлэн хүнд байдалд орсон хохирогчид тусламж үзүүлэх оролдлого хийж байгаад хохирсон хүмүүс хамаарна” гэж заажээ.

“Хохирогч³”-ийг тодорхойлохдоо “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэжээ. Мөн 8.2 дугаар зүйлд хохирогчийн 15 эрхийг хуульчлан тодорхойлсноос хохирсон

¹ Ж.Батмөнх. “Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал” Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан.

² Ж.Батмөнх. “Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал” Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан.

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд

эрхээ сэргээхтэй холбоотой дараах үндсэн 4 эрхийг хуульчилсан байна. Үүнд:

- хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гарган өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;
- гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;
- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;
- шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах.

” Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй¹”, “Төрөөс...хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцана²” гэж тус тус заасан. Гэвч гэмт хэргийн улмаас учирсан хохирол арилахгүй, зөрчигдсөн эрх нөхөн сэргээгдэхгүй байгаа нь нийгмийн өмнө тулгамдсан асуудал боллоо.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хохирогч нь зөвхөн хувь хүн, хуулийн этгээд, хэрэв хувь хүн нас барсан, эсвэл эрх зүйн чадамжгүй болсон бол түүний гэр бүл, төрөл садангийн хүн байж³ болохыг хуульчилжээ. Иймд дам хохирсон этгээдүүдийг гэмт хэргийн хохирогч гэж тооцох онол, хууль зүйн үндэс байгаа юм.

Иймд Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хохирогч гэсэн тодорхойлолт нь НҮБ-ын 1985 оны тунхаглалд заасан тодорхойлолтод агуулгын хувьд үндсэндээ адил учраас манай улсад гэмт хэргийн хохирогчийг өргөн хүрээгээр авч үзэх хандлага нэгэнт тогтсон гэсэн дүгнэж болно.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд

² Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлд

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8-р зүйлийн 1-д

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хохирогчийн тухай ойлголт нь объектив (*агуулга*) ба субъектив (*хэлбэр*) шалгууруудын албан ёсны нэгдэл мөн. Объектив шалгуураар илэрхийлэгдэж байгаа (*de facto*) хохирогч нь материаллаг эрх зүйгээр, субъектив шалгуураар илэрхийлэгдэж байгаа хохирогч нь процессын нэг оролцогчийн хувьд (*de jure*) хууль ёсоор хүлээн зөвшөөрөгддөг.

Гадаад улс орнуудын эрүүгийн материаллаг эрх зүйн ойлголтоор гэмт хэрэгт бодитойгоор хохирсон нийт хохирогчдыг гэмт хэргийн бодит хохирогч (*actual victims*), гэмт хэрэгт бодитойгоор хохирсон боловч ямар нэгэн шалтгаанаар албан ёсны тоо бүртгэлд ороогүй бодит хохирогчдыг нуугдмал (*latent victims*) хохирогч гэж тооцож байна.

Хохирогчийн эрхийг хамгаалах, хангах олон улсын стандарт нь дараах хандлага чиглэлтэй байгаа нь бодлого баримтын дүн шинжилгээгээр харагдаж байна. Үүнд:

➤ **Шударгаар хандуулах эрх** төр нь өөрийн нутаг дэвсгэр дээр гэмт хэргийн хохирогчид учирсан хохиролтой холбоотой хууль зүйн болон ёс суртахууны хариуцлагыг хүлээх

➤ **Мэдэх эрх**; хохирогч нь гэмт хэрэгтний тухай болон байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс гаргасан шийдвэрийн тухай тодорхой мэдээлэл хүлээн авах

➤ **Аюулгүй байх эрх** гэмт хэрэгтэн, түүний төрөл төрөгсөд, хамсаатан, дотны нөхдийн өшөө авалт, сүрдүүлгээс айж байгаа хохирогч нь гэмт этгээдийн эрхийн зарим нэмэгдэл хязгаарлалтыг шаардсан, төрийн эн тэнцүү хамгаалалтанд байх

➤ **Зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх, хохирлоо арилгуулах эрх**; гэмт хэргийн улмаас учирсан бие махбодийн ба сэтгэцийн гэмтэл, сэтгэл зүйн хор уршиг, алдагдсан орлого, эмчилгээний төлбөр, мөн төрөөс тогтоосон, нийгмийн халамжийн тогтолцооноос нөхөн төлбөр авах

➤ **Нийгмийн халамж, дэмжлэг туслалцаа авах эрх** гэмт хэргийн хохирогч нь эхний ээлжид эрх зүйн туслалцаа, нийгэмийн дэмжлэг, хамгаалалтыг бололцооны хэрээр авах зэрэг эрхээр тодорхойлогдож байгаа юм.

Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан хохирогчийн эрхийг олон улсын стандартад нийцүүлэн дараах байдлаар нь:

-  Шударгаар хандуулах, шүүхээр хамгаалуулах эрх;
-  Өөрийгөө өмгөөлөх, бусдаар өмгөөлүүлэх ба төлөөлүүлэх эрх;
-  Нотлох эрх;
-  Мэдэх эрх;
-  Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
-  Хөндөгдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх;
-  Аюулгүй байх эрх;
-  Нийгмийн халамж, тусламж авах эрх гэж ангилж болно.

1. **Хохирогчийн шударгаар хандуулах эрх** нь олон улсын хохирогчийн хамгаалалтын тухай олон улсын баримт бичгүүдэд зааснаар: хүн бүр хууль, шүүхээр хамгаалуулах; төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх; гэмт хэрэгт хохирсон гэдгээ хүлээн зөвшөөрүүлж, хохирогчоор тогтоолгох; эрх мэдэл бүхий байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгээгүй тухай шийдвэрийг эргэж авч үзэх талаар өргөдөл гомдол гаргах, шүүхэд шууд хандах эрх зэргийг тунхагласан байна. Эдгээр баримт бичгүүдэд зааснаар төр нь төрийн байгууллага, түүний албан тушаалтнаас гэмт хэргийн хохирогчидтой шударгаар харьцах, тэдний эрэлт хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, нийгмийн халамж, туслалцаа авах, зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх, мэдээлэл авах талаарх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх төрийн хариуцлагыг тогтоож өгсөн байна.

Хуулиар эрх олгосон бол хамгаалах хэрэгслийг нь хамт өгөх ёстой” (Ubi jus ibi reme dium) гэсэн римийн эрх зүйн хэлц үг бий. Төр нийгмийн зүгээс хүний тодорхой эрх, эрх чөлөө бодитойгоор хэрэгжих баталгааны зохих механизмыг бүрдүүлээгүй бол хувь хүний эрх зүйн байдал нь зөвхөн тунхаг шинжээр үлдэнэ.

Эрх зүйн баталгаа нь улс төр, нийгмийн болон хууль зүйн баталгаанаас бүрдэх учраас гэмт хэрэгт хохирсон этгээдийн эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тусгай байдал гол байр суурьтай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хувь хүний эрхийг хангах механизм нь: ”Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны зорилго зорилтыг нарийн тодорхойлох, оролцогч нэг бүрийн эрх зүйн байдлыг нэгдмэл логик дэс дараатайгаар журамлах, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд хувь хүний эрхийг бодитойгоор хангах хамгаалах, түүний дотор албан тушаалтнаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар олгогдсон зорилтуудыг хангах үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн үр дагаварыг тогтоох, мөн эрүүгийн журмаар хууль бус, үндэслэлгүйгээр мөрдөгдөж байгаа этгээдийг цагаатгах арга хэрэгслийн тогтолцоог журамлах зэргийг багтаасан арга хэрэгслийн тогтолцоо” мөн гэж тодорхойлж болно.

“Иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй¹ гэж заасан.

Хохирогчийн шүүхээр хамгаалуулах эрх нь өөртөө: өөрийн субъектив эрхийг хамгаалуулахын тулд шүүхэд хандах эрх; энэ талаар мэдээлэл авах эрх; шүүхийн бүрэлдэхүүн хууль ёсны байх эрх; шүүх ажиллагаанд биеэр оролцох эрх; гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо арилгуулах эрх; шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхүүд тус тус багтана.

Манай өнөөгийн нөхцөлд гэмт хэрэгт хохирсон этгээд нь шүүхэд хандаж, шударга шийдвэр гаргуулах боломжтой ч уг шийдвэрийг ханган биелүүлэх, эрхийг нь нөхөн сэргээх, нийгмийн халамж тусламж дэмжлэг авах, эцэст нь аюулгүй байдлаа хангуулах механизм, эрх зүйн тодорхой зохицуулалт илт дутагдаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлд: *Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх*” гэж заажээ. Энэ хуулийн 1.4.37 дугаар зүйлд зааснаар “яллах” тал гэдэгт прокурор, “өмгөөлөх тал” гэдэгт шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний хариуцагч, түүний төлөөлөгчийг ойлгоно гэжээ. Энэ агуулгаар шүүх хуралдааны мэтгэлцээн нь зөвхөн улсын яллагч ба шүүгдэгч, түүнийг өмгөөлөх талын */шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний хариуцагч, түүний төлөөлөгч/* хооронд явагдах учраас, хохирогч, иргэний нэхэмжлэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, төлөөлөгч, өмгөөлөгчид нь нь мэтгэлцэхдээ прокуророор дамжуулах, эсвэл шүүх хуралдаан дээр мэтгэлцэх боломжгүй, зөвхөн 1.4.1.20 дугаар зүйлд заасан

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд зааснаар:

оролцогч талууд тэгш эрхтэй байх ерөнхий нөхцөл буюу хүсэлт, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэхэд оролцох, үг хэлэх зэргээр хязгаарлагдмал хүрээнд “мэтгэлзэх” логик харагдаж байгаа юм.

Хууль зүйн ухааны доктор, профессор Б.Бат-Эрдэнэ: “Мэтгэлцээний сонгодог хэлбэр бол мэтгэлцээний эхлэл буюу гараа нь талуудад адил байх боломжийг хангаж өгөхийг ихээхэн чухал гэж үздэг. Иймээс шүүхийн хэлэлцүүлгийн эхэнд талууд өөр, өөрийн байр суурийг илэрхийлсэн эхлэлийн үг ээлжлэн хэлдэг онцлогтой. Харин манай орны хувьд шүүхийн хэлэлцүүлэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурор оролцож, яллах, цагаатгах талын нотлох баримт нэгэн зэрэг цуглуулсан улсын яллагч яллах дүгнэлт уншиж сонсгохоос эхэлнэ /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1.1 дугаар зүйлийн Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоосны дараа гэм буруутай бол Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй бол цагаатгах асуудлыг хянан шийдвэрлэнэ/

Энэ нь яллах талын эхлэлийн үг юм. Харин хэлэлцүүлгийн эхэнд яллагчтай адил эхлэлийн үг хэлэх эрхийг өмгөөлөх талд олгоогүй юм”¹ гэж онцлон тэмдэглэжээ. Тэрээр цааш нь: “Мэтгэлцүүлэн шүүдэг буюу мэтгэлцэх зарчим бүхий улс орнуудад шүүгч төвийг сахисан байр суурьтай байх ба байцаалтыг шууд явуулахгүй. Мөн төвийг сахисан байдлаа хадгалахын тулд байцаалтад оролцож, асуулт тавихаас аль болох зайлсхийдэг журамтай. Хууль зүйн ухааны доктор, профессор Ж.Бямбаа: “Манай шинэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “оролцогчдын” болон “бусад оролцогч”-дын процессын баталгааг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, орчин цагийн шаардлага, нийтлэг жишгийн дагуу эрс нэмэгдүүлсэн боловч талуудын эрх тэгш байх болон мэтгэлзэх зарчмын жинхэнэ утгаар үйлчлэх цар хэмжээг анхан шатны шүүн таслах ажиллагааны хүрээнээс өргөжүүлэн авч үзэх онол, практикийн үндэслэл одоогоор алга” гэж дурдсан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дугаар зүйлийн 1.37 хэсэгт “яллах тал” гэж прокурорыг, 1.16 хэсэгт “өмгөөлөх тал” гэж шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч,

¹ Ж.Батмөнх. “Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал” Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан.

иргэний хариуцагч, түүний төлөөлөгчийг ойлгоно гэжээ. Харин хохирогч нь шүүх хуралдаанд ердийн хуульд заасан журмын дагуу мэдүүлэх хүрээнд оролцох учраас гэмт хэрэгтнийг хохирогчийн өмнөөс бус, харин төрийн нэрийн өмнөөс ялагч-прокурорын саналтай нийцээгүй зөрөөтэй байгаа өөрийн байр суурийг бүрэн дүүрэн илэрхийлэх боломжгүй юм.

Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд хохирогч нь мэтгэлцээний яллах талын бүрэн гишүүнээр хязгаарлахгүй, улсын яллагчтай байр суурь зөрөөтэй үед шүүх хуралдаан дээр өөрөө хувиараа яллах эрхтэй.

Судлаачийн үзэж байгаагаар мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг жинхэнэ ёсоор хангахын тулд нэг талаас, талуудын мэтгэлцэх, байр сууриа харилцан илэрхийлэх боломж адил тэгш байх, нөгөө талаас хохирогчийг яллах талын бүрэн эрхт гишүүний байр суурийг эзлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “яллах тал гэж прокурор, өмгөөлөх тал гэж хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, түүний төлөөлөгчийг” гэж нэмэлт өөрчлөлт оруулах саналтай. Цаашид шүүх хуралдааны процедурыг шүүхийн мэтгэлцээний сонгодог загварт оруулж, өөрчлөх шаардлагатай. Материаллаг хэм хэмжээний хэрэгжилтийг хангах процедур, процесс байхгүйгээр зөвхөн тунхаглалын шинж чанартай болно.

Монгол Улсын Үндсэн хуульд: “иргэн нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”¹ гэжээ.

Өргөдөл гаргаж, шийдвэрлүүлэх боломж нь хохирогчийн байцаан шийтгэх ажиллагааны хамгийн гол чухал эрхүүдийн нэг мөн. Энэ эрхийн тусламжтайгаар хохирогч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд нөлөөлөх боломжтой болно. Өргөдөл нь хүсэлт болон гомдол гаргасан шинжтэй байж болно.

Хохирогчийн хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохих зүйл, заалтуудад тодорхой заасан байна. мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах /8.2.1.3/; шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 12 дахь хэсэг.

татгалзан гаргах тухай хүсэлт гаргах /8.2.1.11/ эрхийг тусгайлан зааж өгсөн боловч, хууль тогтоогч нь хохирогчоос гомдол, хүсэлт гаргах тохиолдол бүрийг нарийвчлан зааж өгөөгүй юм.

Монгол Улсын ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1.12 хэсэгт : эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах эрхийг тусгажээ.

2.Хохирогчийн өмгөөлөх, өмгөөлүүлэх ба төлөөлүүлэх эрх. Монгол Улсын Үндсэн хуулийн *Арван зургадугаар* зүйлд хүн бүрийн "өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах" эрхийг нь баталгаажуулсан юм. Монгол Улсын ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1.12 хэсэгт: "...өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;"-ийг хангах тухай заажээ.

Судалгаагаар хуулийн байгууллагын ажилтнууд хохирогчид өмгөөлүүлэх эрхтэйг танилцуулдаг гэж хохирогч нарын 60 хувь, харин хуулийн байгууллагын ажилтнуудын 99.3 хувь нь хохирогч нарт өмгөөлүүлэх эрхтэйг нь танилцуулдаг хэмээн¹ тус тус хариуллаа.

Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан өмгөөлөгч нар хэлэхдээ хохирогчийн хувьд өмгөөлөгч авна гэдэг нь хохирсон дээрээ дахин хохироход хүрдэг тул гэмт этгээдтэй харьцуулахад өмгөөлөгч авах нь бага байдаг гэж үзсэн билээ. Өөрөөр хэлбэл хуульд аль аль нь өмгөөлүүлэх, төлөөлүүлэх эрхээр хангагдах ёстой ч бодит амьдрал дээр хохирогч тэр болгон өмгөөлөгч авах эдийн засгийн чадамжгүй, тэгээд ч хуулийн байгууллагын ажилтнуудын хандлага ч хохирогчийн энэ эрхийг хангах тал дээр санаачлагагүй ханддаг байна.

Хохирогчийн эрх зүйн байдал нь түүний эрхийн чадвар, чадамжаас шалтгаалан өөр өөр байна. Хохирогчийн эрхийн чадвар бол гэмт халдлагаас шүүхээр хамгаалуулах эрхийг эзэмших чадвар мөн. Иймд: нас, бие, сэтгэл санааны байдлаас хамаарахгүй гэмт хэргийн улмаас хохирсон хүн болгон эрхийн чадвартай байна гэж үзнэ. Өөрийн эрх, эрх чөлөөг өөрөө хамгаалах болон бие дааж байцаан шийтгэх ажиллагаанд

¹ Ж.Батмөнх. "Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал" Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан

оролцох эрхтэй байх буюу эрх эдэлж, үүрэг хүлээх чадамжийн асуудлыг шийдвэрлэх нь ихээхэн нарийн төвөгтэй байдаг.

3. Нотлох эрх. Монгол Улсын ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлд зааснаар нотлох баримтын эх сурвалжид, “Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадлагаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл” байхаар заажээ. Мөн хуулийн 8.2.1.2 дугаар зүйлд хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах; 16.1 дүгээр зүйлд тэднээс эрхээ эдлэх энэ хэлбэрийг “нотлох баримтыг цуглуулах нэг” арга гэж хуульчилсан байдаг.

Хэрэв хохирогч буюу түүний төлөөлөгч нь эрүүгийн хэргийн талаар нотлогдвол зохих байдлуудыг баталсан, эсвэл үгүйсгэсэн мэдээлэл, баримт сэлт байгаа бол тэд шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчид гаргаж өгөх эрхтэй. Энэ тохиолдолд мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хохирогч болон түүний төлөөлөгчийн гаргаж өгсөн эд мөрийн баримт, буюу бичиг баримтыг олж авсан нөхцөл байдлын талаар мэдүүлэг авах үүрэгтэй. Мөн нотлох баримтыг илрүүлсэн нөхцөл байдал, тэдгээрийн онцлог шинжүүдийг тодорхойлсон протокол үйлдэнэ. Хохирогч, түүний төлөөлөгчид нь нотлох баримт гаргаж өгөх эрхээ хэрэгжүүлэх явцдаа нотлох баримтыг илрүүлэх зорилгоор явуулж байгаа мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

Хохирогчоос баримт сэлт гаргаж өгөх нь сайн дурын ажиллагаа мөн. Хэрэв хохирогчийн зүгээс баримт сэлт гаргаж өгөхгүй байгаа тохиолдолд тухайн эд зүйлийг хураан авах, шаардлагатай бол нэгжлэг хийх боломжийг хуульд тусгасан байна.

Мөн хохирогч нь гэмт хэргийг нотлох зорилгоор мэдүүлэг өгөх эрхтэй. Хохирогч нь энэ эрхээ мэдүүлэг өгөх, эсвэл өөрөө бичиж өгөх

замаар хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд мэдүүлэг өгөх санаачилга нь хохирогчийн талаас гарсан байна. Харин хохирогч сайн дураар мэдүүлэг өгөөгүй тохиолдолд энэ үйлдэл нь эрх бус, харин үүрэг болон хувирч байгаа юм. Иймд хохирогчийн мэдүүлэг нь зөвхөн өөрийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэгсэл, түүний эрх төдийгөөр үл хязгаарлана

Мөрдөн шалгах ажиллагааны боломжуудын дотор мэдүүлэг өгөх эрх нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой: хохирогч-хувь хүн нь зөвхөн өөрөө мэдүүлэг өгөх замаар энэ эрхээ хэрэгжүүлж болно. Хувь хүний болон хуулийн этгээд-хохирогчийн төлөөлөгчийг байцаах тохиолдолд гэрчийг байцаах журмаар асууна.

Хохирогчоос нотлох эрхийнхээ хүрээнд гэмт хэрэгтнийг халуун мөрөөр нь буюу цаашид эрэн сурвалжлах, түүнийг илэрсэн нөхцөлд баривчлах эрх байгаа юм. Мөн техникийн болон бусад туслалцаа үзүүлэх боломжтой хохирогч-хуулийн этгээдийг байцаан шийтгэх ажиллагаанд татан оролцуулах, мөн гадаадын зарим орны туршлагаар, эрэн сурвалжлах ажиллагаанд хувийн хамгаалалтын болон мөрдөлтийн бүтэц, нэгжийг ашиглах ирээдүй ойрхон байна гэдэгт найдаж байна.

Хохирогчоос улсын яллах ажиллагааны хувьд дэмжих нь зөвхөн туслах шинжтэй байдаг. Хохирогч болон түүний төлөөлөгч нь төрийн яллагчаас хараат бус бие даан үйл ажиллагаа явуулах эрхийг хуульчлах шаардлагатай. Прокурор яллахаас татгалзсан бол хохирогч нь шүүгдэгчийн гэм бурууг нотлох бүх үүргийг хүлээн авсанаар, илүү чухал ач холбогдолтой болох ёстой.

4. Мэдэх эрх (мэдээлэл авах, мэдээллээр хангуулах эрх). Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын 19 зүйлд: "хүн бүр мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан ...хүлээн авах эрхтэй", **Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын Тунхаглалын 4 зүйлд:** " ...Албан болон албан бус механизмаар дамжуулан хохиролоо нөхөн төлүүлэхийг зорьсон хохирогчид тэдний эрхийг нь мэдээлж тайлбарлаж байх...Хүнд гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны хугацааны явц, үр дүн, хохирлын хэмжээ, тэдний оролцох талаар мэдээлэл өгөхөөс гадна тэд энэ тухай мэдээлэл хүсвэл зохих мэдээллээр хангана" гэж тус тус заажээ. **Европын Холбооны Сайд нарын Хорооноос гишүүн улсуудад өгсөн эрүүгийн эрх ба эрүүгийн процессын хүрээнд хохирогчийн**

харьцангуй байдлын Зөвлөмж ¹ R (85) 11. А.(Цагдаагийн түвшинд) гэсэн §2.3-т: ” Цагдаагийн байгууллага нь хамтын ажиллагааны болон эрх зүйн болон практикийн тусламж, мөн эрх зүй зөрчигчийн болон төрийн талаас нөхөн төлбөр авах боломжийн тухай хохирогчид мэдээлэх ёстой. Хохирогч нь цагдаагийн мөрдөн байцаалтын үр дүнгийн тухай мэдээлэл авах боломжтой байх ёстой” гэж тус тус заажээ.

Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хийх, хүлээн авах эрхтэй¹ гэж заасан.

Хохирогч, түүний төлөөлөгч нь өөрийн үндсэн болон байцаан шийтгэх ажиллагааны эрх, үүргийн тухай мэдээллийг байцаан шийтгэх ажиллагааг явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах, эдгээр эрхээ хэрэгжүүлэх боломжийг шаардах эрхтэй.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжоос үзэхэд хохирогчийн эрхийг хангахад чиглэсэн мөрдөн шалгах ажиллагааны ажиллагааны эрх, үүргийг тайлбарлах; эрх үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хоёр үндсэн арга хэмжээг зааж өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан нийт хохирогч нарын 43 хувь нь хохирогчийн эрхийн тухай мэдээллийг их төлөв хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн танилцуулснаар мэдэж авдаг гэж ингэж хариулснаас харагдаж байна. Үүнээс гадна өмгөөлөгчөөсөө, таньж мэддэг хүмүүсээрээ дамжуулан авахын зэрэгцээ хохирогчийн эрхийн талаарх мэдээллийг огт авч байгаагүй буюу өгч байгаагүй гэж арван хохирогч тутмын нэг нь хариулав.

Хүснэгт 1. Хохирогчийн эрхийг тайлбарлах талаар судалгаанд хамрагдсан хохирогч, хуулийн байгууллагын ажилтнуудын хариултын хувийн жин²

Хохирогч	Хуулийн байгууллагын ажилтнууд
Хуулийн үг бүрийг нэг бүрчлэн тайлбарлаж өгдөг (7%)	Хуулийн үг бүрийг нэг бүрчлэн тайлбарлаж өгдөг (16.9%)

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дах хэсэгт
² Ж.Батмөнх. “Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал” Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан

Хуульд байгаа заалтыг ерөнхийд нь тайлбарлаж өгдөг (28.6%)	Хуульд байгаа заалтыг ерөнхийд нь тайлбарлаж өгдөг (45.6%)
Хохирогчид эрх, үүргийг нь уншиж өгдөг (27.6%)	Хохирогчид эрх, үүргийг нь уншиж өгдөг (27.2%)
Хохирогч эрхээ мэдсэн байдаг тул өөрөөр нь уншуулдаг (5.4%)	Урьдаас бэлтгэн боловсруулсан хохирогчийн эрх үүргийг сайтар уншуулдаг (5.1%)
Өмгөөлөгчөөр дамжуулан эрх, үүргийг нь танилцуулдаг (7.6%)	Өмгөөлөгчөөр дамжуулан эрх, үүргийг нь танилцуулдаг (3.7%)
Тайлбарлаж өгдөггүй (23.8%)	Хариулахад хүндрэлтэй (1.5%)

Хуулийн байгууллагын ажилтнуудын бараг тал орчим хувь нь хохирогчид эрх үүргийг нь ерөнхийд нь тайлбарлаж өгдөг гэж үзсэн нь бусад хариултуудаасаа хамгийн давтамж өндөртэй хариулт болж байна. Харин хохирогч нарын хувьд мөн ерөнхийд нь хэлж өгөх эсвэл эрх үүргийг нь тайлбарлах маягаар эрх үүргийг нь танилцуулдаг гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан хохирогч нарын дээрх хариултад дүн шинжилгээ хийж үзвэл гурван хохирогч тутмын нэг нь хуулийн байгууллагын ажилтнуудын зүгээс эрхийг нь огт тайлбарлаж өгдөггүй эсвэл өмгөөлөгчөөр дамжуулан эрх үүрэгтэйгээ танилцсанаас үзэхэд хохирогчид эрх үүргийг нь тайлбарлаж өгөх үүргээ биелүүлэхгүй байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн ер нь хохирогч эрхийнхээ тухай мэдээллийг өөрөө уншиж судалдаг гэж чанарын судалгаанд оролцсон хохирогч, өмгөөлөгч нар тэмдэглэсэн юм.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулж байгаа этгээд нь бүх ажиллагааг хийж дууссан, хэргийг шийдвэрлэх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл энэ тухай хохирогч, түүний төлөөлөгчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаныг мэдэгдсэний дараа хохирогч, түүний өмгөөлөгчид хэргийн бүх материалыг, харин иргэний нэхэмжлэгч түүний төлөөлөгчид зөвхөн иргэний нэхэмжлэлд холбогдох хэсгийг танилцуулна. Хохирогчийн өмгөөлөгч хүсвэл түүнд хэрэгт авагдсан эд мөрийн баримт, соронзон болон дүрс бичлэгийг танилцуулж болно. Хохирогчид хэргийн материал танилцуулсан тухай тэмдэглэл үйлдэх ба түүнд ямар материал танилцуулсан, хохирогч ямар хүсэлт гаргасан зэргийг тусгана. Хохирогч хэргийн материалтай танилцах үед бичгээр хүсэлт гаргасан бол хэрэгт

хавсаргана. Хэргийн материалтай танилцах үед хохирогчоос гаргасан хүсэлтийг хэрэг бүртгэгч хүлээн авч хангах, эсвэл хэрэгсэхгүй болгож энэ тухай тогтоол гаргана. Хохирогч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоосон хугацаанд хэргийн материалтай танилцах ба хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийн материалтай танилцах боломжийг бүрдүүлнэ. Хохирогч нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол прокурорт гомдол гаргаж болно.

Монголд мэдээлэл авах эрхийн хувьд хохирогч, түүний төлөөлөгч нь өөрийн үндсэн болон байцаан шийтгэх ажиллагааны **эрх, үүргийн тухай мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааг явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах, эдгээр эрхээ хэрэгжүүлэх боломжийг шаардах эрхтэй боловч**, гэмт хэргийн талаарх хэрэг шийдвэрлэх ажиллагааны **цар хүрээ, хугацаа, явц, гаргасан шийдвэрийн талаар болон гэмт этгээдийн талаарх мэдээллийг авах нөхцөл бололцоо хомс** байна.

Бидний үзэж байгаагаар мөрдөн шалгах ажиллагааны онол, практик, гадаад улс орнуудын туршлагаар гэмт хэрэгт өртөгдсөн этгээдийг гэмт хэргийн хохирогчоор тооцож, түүнд эрх, үүргийг нь танилцуулахын хамт, түүний эрхийг бичиж гардуулах үүргийг эрх бүхий алба хаагч хүлээх шаардлагатай.

6. Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах. Үндсэн хуульд: “Монгол хэл бол албан ёсны хэл мөн. Энэ нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө¹” гэж заасан. ЭЭХХШТХ-д: “Мөрдөн шалгах ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулах” болон “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд нь монгол хэл мэддэггүй бол өөрийн эх буюу мэддэг хэл, бичгээр, хараагүй, хэлгүй, дүлий этгээд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх, гомдол гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх, хэргийн холбогдох бүх материалтай бүрэн танилцах эрхээр хангагдах” зарчмыг тусгаж өгсөн юм.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 8-р зүйлийн 2 дахь хэсэг.

Монгол хэл мэдэхгүй хохирогч нь орчуулагч, харин хараагүй, хэлгүй, дүлий хохирогч нь хэлмэрчээр дамжуулан байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхээр бүрэн хангагдсан юм.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хохирогчийг орчуулагч, хэлмэрчээр хангах үүрэг хүлээнэ.

- Гэмт хэргийн хохирогч нь хэл мэддэг, аль хэр мэддэгийг тодруулах;
- Хохирогчид орчуулагч хэлмэрчтэй байх эрхийг тайлбарлах;
- Хохирогчийг орчуулагчаар хангах зэрэг ажиллагаа явуулна.

7. Хөндөгдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх. Монгол Улсын Үндсэн хуульд: иргэн нь “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх”, төр нь “хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар” заажээ. Хохирогч нь эрүүгийн хэрэг үүсгэхээс шүүхийн хэлэлцүүлэг эхлэх хүртэл хугацаанд гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлоо нөхөн төлүүлэх буюу сэргээлгэх, энэ талаар шаардлага тавих эрхтэй. Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд хохирогч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсвэл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд, тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ. Эрүүгийн хэрэгт холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхгүй. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ нь хэргийн талаар нотолбол зохих асуудлын /ЭХХШТХ-ийн 16.2/ нэг учраас түүнийг тогтоох үүрэг шүүхийн өмнөх байцаан шийтгэх ажиллагааг явуулах байгууллага, албан тушаалтанд ногдоно.

Хэрэв гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан тухай хангалттай мэдээлэл байвал хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүх, прокурор нь иргэний нэхэмжлэл гаргах боломжоор хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Эдгээр арга хэмжээнд:

- Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан этгээдийг тогтоох;

- Иргэний нэхэмжлэлийг хангах үүднээс эд хөрөнгийг эрэн сурвалжлах /үзлэг, нэгжлэг хийх/;
- Эд хөрөнгийг битүүмжлэх;
- Түүний бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа орно

ДҮГНЭЛТ

Хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нэхэмжлээд зогсохгүй, мөн бие махбодийн болон сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх эрхтэй. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох явцад, эрх зүйн нэгэнт тогтсон уламжлалыг хадгалахын хэрээр нийгмийн эрх зүйн өндөр ухамсрын хүмүүжлийн нэг чухал баталгаа болсон хууль тогтоомжийн тогтвортой байдал хангагдана. Эрх зүй зөрчигч, түүний төлөө хариуцлага хүлээж байгаа этгээдээс хор уршиг арилгуулах эрхийн эд хөрөнгийн агуулга нь: эд хөрөнгөө буцаан авах эрх; үрэгдсэн эд хөрөнгөө нөхөн төлүүлэх эрх; гэмт хэрэгт хохирох явдалд учирсан зардлыг нөхөн төлүүлэх эрх; үйлчилгээ авах эрх /гэмт хэргийн улмаас гэмтсэн эрүүл мэнд, эд хөрөнгийн байдлаа нөхөн сэргээх/; зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх; сэтгэл санааны хохирлоо арилгуулах эрх зэргээс бүрдэнэ.

Мөрдөн шалгах ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл нь иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө болон эд хөрөнгөтэй холбоотой үүссэн харилцаа буюу иргэний эрх зүйн зохицуулах зүйлд хамаарах учраас, иргэний болон хөдөлмөрийн маргаанаас үүссэн нэхэмжлэлийг хангах ажиллагааны журам адил учраас, энэ асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгалаа олсон байна.

---o0o---